

**ТСОЛАТ-ИЙН БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРИЙН ХОРООНЫ ХУРЛЫН
ПРОТОКОЛ №01**

Хугацаа:

Хурал 2023 оны 05 сарын 15-ны өдөр 337 тоот өрөөнд 14 цагаас эхэлж 18 цагт дуусав.

Ирц:

Хуралд хөтөлбөрийн хорооны ахлагч дэд профессор Д.Хандсүрэн, дэд профессор Д.Ундармаа, дэд профессор Ж.Оюунгэрэл, доктор Т.Насанжаргал, доктор Ш.Доржпагма, доктор С.Одонгэрэл, Х.Мөнхтүвшин, А.Бэлгүүн, Э.Батзаяа, URGENT төслийн менежер доктор Д.Банзрагч нар оролцов. Хурлыг Таримал судлал, Ой, Ландшафтын тэнхимийн эрхлэгч доктор, дэд профессор Д.Хандсүрэн удирдан явуулав.

Хэлэлцэх асуудал:

- Сургалтын төлөвлөгөөний шинэчлэл, өөрчлөлтийн талаарх танилцуулга
- URGENT төслийн хүрээнд шинээр боловсруулж, сайжруулж буй хичээлүүдийн хөтөлбөрүүд
- Шинээр анги нээх болон 2014 оны төлөвлөгөөнд байсан “Жимс ногооны аж ахуй” хөтөлбөрийг дахин хөгжүүлэх, шинээр элсэлт авах тухай

Хэлэлцсэн нь:

- Сургалтын төлөвлөгөөг хэлэлцэх (Англи хэл, Биеийн тамирын хичээлийг 2кр, Нийгмийн ажил 2кр, Төгсөлтийн ажил кредитгүй болгох)
- Бүрэлдэхүүн 5 сургуулийн чөлөөт сонголтын хичээлүүдээс Сургалтын төлөвлөгөөнд оруулах
- URGENT төслийн хүрээнд сайжруулж буй хичээлүүдэд ирүүлсэн төслийн оролцогч талууд болоод ажил олгогч байгууллагын санал, шүүмжийн талаар тус тус хэлэлцэв.
- “Уламжлалт анагаах ухааны эмийн ургамал судлал”, “Жимс ногооны аж ахуй” бакалаврын сургалтын төлөвлөгөөний суурь боловсролын хичээлийг өөрчлөх, нэмэлт оруулах, шинэчлэн сайжруулахаар тус тус хэлэлцэв.

Шийдвэрлэсэн нь:

1. Сургалтын төлөвлөгөөнд хөтөлбөрийн зохицуулагч С.Одонгэрэл чөлөөт сонголтын хичээлүүдийг оруулан засвар хийхээр шийдвэрлэв.
2. URGENT төслийн хүрээнд шинээр болон шинэчлэн сайжруулж байгаа дараах хичээлүүдийг хөтөлбөрийн хорооны гишүүдийн санал, зөвлөмжийг оруулан батлуулан батлуулж, олон улсын төслийн багт хүргүүлэхийг хичээл заадаг багш нарт үүрэг болгов. Үүнд:
 - a. Ландшафтын архитектурын үндэс 3 кредит, багш Х.Мөнхтүвшин
 - b. Ландшафтын архитектурын материал судлал, 3 кредит, багш А.Бэлгүүн
 - c. Ландшафтын архитектурын төсөл-II, 3 кредит, багш А.Бэлгүүн
 - d. Хот суурины цэцэрлэгжүүлэлт, 3 кредит, багш С.Одонгэрэл
 - e. Монументал чимэглэл, 3 кредит, багш Э.Батзаяа
 - f. Ландшафтын архитектурын экологи, 3 кредит, багш Х.Мөнхтүвшин, О.Бүрэнжаргал
3. Ландшафтын архитектурын экологи хичээлийн стандарт хөтөлбөр сайжруулан, идэвхтэй ажиллахыг хичээл заадаг багш нарт сануулав.

4. Уламжлалт анагаах ухааны эмийн ургамал судлалын хичээлийг урьдчилсан магадлан итгэмжлэлийн шинжээчдийн дүгнэлтэнд тулгуурлан засаж, ХААИС-ийн 2023-2024 онд суурь боловсролын хичээлийн загвар оруулан ирүүлэхийг хөтөлбөрийн хорооны зохицуулагч Т.Насанжаргал, доктор С.Одонгэрэл нарт үүрэг болгов.
5. “Жимс ногооны аж ахуй” бакалаврын сургалтын хөтөлбөрийн төлөвлөгөөг жишигт нийцүүлэн өөрчилж, 2023-2024 оны хичээлийн жилд элсэлт авч тус хөтөлбөрийг хөгжүүлж ажиллахыг зохицуулагч Ж.Оюунгэрэлд хариуцуулан ажиллуулахаар шийдвэрлэв.
6. “Архитектур” бакалаврын сургалтын хөтөлбөрийн зарим сонгогдсон хичээлүүдийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, цаг хугацаанд нь чанартай боловсруулан, хариуцлагатай ажиллаж төслийн багт хүргэхийг Агрэкологийн сургуулийн URGENT төслийн багт, хөтөлбөрийн хорооны зүгээс үүрэг болгов.

Протокол хөтөлсөн: Багш

Хянасан: Хөтөлбөрийн хорооны ахлагч



С.Одонгэрэл



Д.Хандсүрэн